

ТАНИЛЦУУЛГА

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл", Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Шинэ саргалтмын бодлого" зэрэг бодлогын баримт бичигт Эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилт, арга хэмжээг тусгасан

Дээрх бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгаа.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангид:

-Эрүүгийн хуулийн ерөнхий ангид гэмт хэргийн хохирлыг хэмжээг инфляцийн түвшинтэй үйлдүүлэн шинэслэн тогтоож, бага хэмжээний хохирлыг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээ, түүнээс доош хэмжээний үлэмж хэмжээний хохирлыг хорин мянган нэгжээс дээш нэг зуун мянга хүртэл нэгжтэй тэнцэх хэмжээний, их хэмжээний хохирлыг нэг зуун мянгаас дээш нэгжтэй тэнцэх хэмжээний төрөг байх өөрчлөлтийг тусгаа.

-Мөнгө угаах болон татаар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн онцлог, олон улсын байгууллагаас Монгол Улсад өгсөн зөвлөмжийг харгалзан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргэ үйлдсэн өдрөөс хойш таван жил байхаар хуулийн төсөлд тусгаа.

-Халдашгүй бүрэн эрхээр "халхавчлан" хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн харуулага хүлээдэггүй, эрүүгийн харуулага гарцаагүй байх, шударга ёсны зарчмыг гажуудуулааг байдлыг халах зорилгоор хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолох өөрчлөлтийг хуулийн төсөлд тусгаад байна.

-Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохмолдолд эрх хасах ялыг 20 жил хүртэл хугацаагаар оногдуулах, өршөөл, уучлал зүүлэхгүй байх гэмт хэргэрт мөнгө угаах, авлигын гэмт хэргийг хамааруулах нэмэлтийг тусгалаа.

-Гэмт хэргэ үйлдсэн нь тогтоогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд гэмт хэргэ үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор үршлээн шинж чанар, хувийн байдал, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж гэмт хэргийг нотлоход дэмжлэгт үзүүлсэн байдлыг харгалзан оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорихоос өөр төрлийн ялыг сонгон оногдуулах, эрүүгийн харууцлагаас чөлөөлөх, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болголоо.

1

Эрүүгийн хуулийн тусгай ангид:

Хорин хоёрдугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэргэ:

Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт 11 төрлийн авлига, албан тушаалын гэмт хэргийг хуульчилсан бөгөөд статистикийг эдгээр төрлөөр авч үзэхэд 22.1 дүгээр зүйлд заасан Эрх мэдэл, албан тушаалын байдлаар урвуулан ашиглах гэмт хэрэг, 22.4, 22.5 дугаар зүйлд заасан Хэхуль авах, өгөх гэмт хэрэг нийт авлигын хэргийн ихэнх хувийг эзэлж байна.

Авлигын гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 2017 онд 658, 2018 онд 858, 2019 онд 894, 2020 онд 1020, 2021 онд 1144, шалгасан эрүүгийн хэрэг 2017 онд 427, 2018 онд 1138, 2019 онд 1300, 2020 онд 1331, 2021 онд 1307, шүүхээр шийдвэрлэсэн хэрэг 2017 онд 44, 2018 онд 84, 2019 онд 68, 2020 онд 114, 2021 онд 160 байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тоо, шүүхээр шийдвэрлэж байгаа хэрэг бүгд өсөж байгааг харуулж байна.

Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан Эрх мэдэл, албан тушаалын байдлаар урвуулан ашиглах гэмт хэргийн үндсэн болон хүндэрүүлэх бүрэлдэхүүн нь адилт хэмжээний ял харууцлага оногдуулахаар заасан байгааг алхамтай байхаар өөрчлөх, энэ бүлгийн зарим төрлийн гэмт хэргийн шинжийг тодорхой болгох, зарим гэмт хэргийг шинээр нэмж хуульчлах, энэ бүлэгт заасан гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах зэрэг өөрчлөлтийг хийж авлигатай тэмцэх төрлийн бодлогыг чангатгах шаардлагатай байна.

Хуулийн төслийн гол үзэл баримтлалын нэг бол Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой бүлгийг бүхэлд нь хөндөж байгаа бөгөөд ингэхдээ энэ бүлэгт заасан гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах, тухайлбал, торлох ялын нэг нэгж нь хоёр мянган төгрөгтэй тэнцүү байхаар, хүндэрүүлэх бүрэлдэхүүнээс торлох ялыг хасах, хорих ялын хэмжээг нэмэгдүүлэх, үүнтэй үйлдүүлэн нийтийн албанд ажиллах эрх хасах ялыг 2-8 жилийн хугацаагаар, эсхүл хорин жил хүртэл хугацаагаар хасах, авлигын гэмт хэрэгт өршөөл, уучлал зүүлэхгүй байх өөрчлөлтийг тусгасан бөгөөд хорих ялын хэмжээг нэмж байгатай холбогдуулан хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдэнэ гэж ойлгож болно.

"Нийтийн албан тушаалтан" гэдэгт Авлигын зэрэг хуулийн 4.1-д заасан албан тушаалтнаас гадна байнга болон түр хугацаагаар байгуулагдсан хамтын шийдвэр гэрлэх чиг үүрэг бүхий хороо, комиссын гишүүн, эдгээртэй адилтгах ажил, үйлчилгээ эрхэлж байгаа этгээдийг хамааруулах нэмэлтийг тусгаад байна.

-Эрх мэдэл, албан тушаалын байдлаар урвуулан ашиглах (22.1) гэмт хэргийн үндсэн болон хүндэрүүлэх бүрэлдэхүүний ял харууцлага адил хэмжээтэйг оногдуулахаар заасан давхардал, зөрчлийг арилгаж, хүндэрүүлэх бүрэлдэхүүний (22.2, 22.3) торлох ялыг хасаж, бусад ялын хэмжээг нэмэгдүүлэх өөрчлөлтийг тусгаа.

-Нийтийн албан тушаалтан хэхууль авах (22.4) гэмт хэргийг онц хүндэрүүлэх буюу хясан боогдуулах аргаар, үйлдсэн, эсхүл их хэмжээний хэхууль (22.3) авсан, улс төрд нөлөө бүхий этгээд, зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол (22.4) ялын бодлогыг чангатгах өөрчлөлтийг тусгаа.

2

-Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах (22.6) гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний ял хариуцлгатаас торгох ялын хасаж, эрх хасах ялыг нэмэгдүүлэв.

-Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх (22.7), Дугаараа аашлах (22.11) гэмт хэргийн улмаас их хэмжээний хохирол учруулсан бол хүндрүүлэх бүрэлдэхүүнд хамааруулахаар, Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах (22.8) гэмт хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учруулсан бол энэ гэмт хэргэт тооцохоор, Төрийн өмчийн төсвийн бүс хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах (22.9) гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний эрх хасах ялыг нэмэгдүүлэх, хүндрүүлэх бүрэлдэхүүнд эрх хасах ялыг нэмэхээр тус тус тусгаад байна.

-Үндэслэлгүйгээр хөрөнөжих (22.10) гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнээс торгох ялыг хасаж, нийтийн албанд ажиллах эрх хасах нэмэгдэл ял болон зөрчих эрхийг хягдлаарлах, хориг ялын бодлогыг чангатгасан.

-Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд төрийн өмчийн, төрийн өмчинд оролцоотой хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан үндсэн бол хүндрүүлэх зохицуулалтыг нэмэв.

-Нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хахууль авах гэмт хэргийг 22.13-т тусад нь тусган, ялын бодлогыг чангатгав.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн Хорин хоёрдугаар бүлгийн зарим зүйлд заасан авлигын зарим гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй байх, авлигын хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх, мөргөшсөн шүүгчээр шийдвэрлүүлэх үүднээс давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэдэг байх, давж заалдах эрхийг Улсын дээд шүүхэд хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулна.

Арван есдүгээр бүлэгт заасан Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээ.

-Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Монгол Улсын Үндсэн хуульд хориглосон үйлдлийг Эрүүгийн хуульд гэмт хэрэг болон тусгах хэрэгцээ, шаардлага туссан тул Эрүүгийн хуулийн Арван есдүгээр бүлэгт Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх зорилгоор ард нийтийн санал асуулга явуулах гэмт хэргийг шинээр томьёолж, гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд хоёрроос найман жил, хүндрүүлэх бүрэлдэхүүнд таваас арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах нэмэлтийг тусгана.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Ард нийтийн санал асуулга явуулах гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг явуулах харьяаллыг Татнуулын байгууллагад хамааруулах өөрчлөлтийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ард нийтийн санал асуулгын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

Хуулийн төсөл батлагдсанаар Эрүүгийн хуулийн холбогдох бүлэг, зүйлд заасан гэмт хэргийн гаралт буурах, авлига, албан тушаалтантай тэмцэх төрийн бодлого чангарч, эрүүгийн хармуцлага гарцаагүй байх, шударга ёсны зарчим улам бүр баталгаажна гэж үзэж байна.

Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэхээр Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т заасны дагуу тус намны албан ёсны цахим хуудсанд 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр байршуулсан. Түүнчлэн хуулийн төслийг олон нийтэд танилцуулж, хэлэлцүүлэх хэлэлцүүлгийг Соёлын төв оронд зохион байгуулж, уг хэлэлцүүлэгт 400 орчим хүн хамрагдлаа.

Хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, хуулийн төслийн үр нөлөөний судалгааг холбогдох аргачлалын дагуу хийсэн бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар гарах зардлын тухайд материаллаг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа тул зардал үүсэхгүй болно.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ